

БАТЛАВ.
НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГА Н.НАРАНБААТАР

НИЙСЛЭЛИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР “ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН
АВТОМАШИН (УЛААНБААТАР ХОТ)” ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ
АВТОМАШИНЫ АВТОМАШИН, ДАГАЛДАХ ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙГ
НИЙЛҮҮЛЭХ НИЙЛҮҮЛЭГЧИЙН СОНГОН ШАЛГАРУУЛАХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

2026 оны 05 дугаар сарын 05 өдөр

Улаанбаатар хот

ТШЗ-ны холбогдох заалт	А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ
ТШЗ 1.1	Захиалагч: Нийслэлийн Эрүүл мэндийн газар
ТШЗ 1.1	Тендер шалгаруулалтын нэр: Түргэн тусламжийн бүрэн тоноглогдсон автомашин (Улаанбаатар хот)
ТШЗ 1.2	Тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: “Багцгүй”
ТШЗ 1.3	Дотоодын үйлдвэрээс худалдан авах бараа байгаа бол тодорхой бич: Үгүй
ТШЗ 1.4	Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: Үгүй
ТШЗ 2.1	Санхүүжилтийн эх үүсвэр нь: Нийслэлийн төсвийн хөрөнгө Гэрээний нөхцөл: Санхүүгийн түрээс (Лизинг) – 3 жилийн хугацаатай
ТШЗ 2.1	Нийт төсөвт өртөг: 4,416,000,000 (Дөрвөн тэрбум дөрвөн зуун арван зургаан сая) төгрөг. Тухайн онд санхүүжих: 2,192,691,200 (хоёр тэрбум нэг зуун ерэн хоёр сая зургаан зуун ерэн нэгэн мянга хоёр зуун) төгрөг.
Б. АГУУЛГА	
ТШЗ 10.1	Тендер шалгаруулалтын баримт бичгийн талаар тодруулга авах хаяг: Хүлээн авагчийн нэр: Нийслэлийн Эрүүл мэндийн газар, Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо, Ж.Самбуугийн гудамж, Нийслэлийн Засаг захиргааны III байр, 2 дугаар давхар Нийслэлийн Эрүүл мэндийн газар, Утас: 77990101 https://www.emg.ub.gov.mn/ Цахим шуудангийн хаяг: ubhd@emg.ub.gov.mn Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах бол энэ тухай хүсэлтийг тендерийн нээлтээс өмнө бичгээр захиалагчид гаргаж болно. Захиалагч тодруулга авах хүсэлт хүлээн авснаас хойш тодруулгыг тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө яаралтай бичгээр гаргана. Захиалагч тодруулга, нэмэлт мэдээлэл авах хүсэлтийн хариуг хүсэлт

	гаргагчийн нэрийг дурдалгүйгээр албан бичгээр гаргана. Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичгийн салшгүй хэсэг болох тодруулга, нэмэлт, өөрчлөлтийг тендер хүлээж авах эцсийн хугацаа хүртэл шалган нягталж, түүнд нийцүүлэн тендер бэлтгэнэ.
ТШЗ 11.1	Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгуулах эсэх: Үгүй
В. ТЕНДЕР БЭЛТГЭХ	
ТШЗ 15.1	Хувилбарт санал ирүүлэхийг: Зөвшөөрөхгүй
ТШЗ 16.2	Ерөнхий шаардлагыг магадлах баримт бичиг шаардах эсэх: “Тийм” а) Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар ирүүлэх. б) Тендер шалгаруулалт зарласнаас хойш хугацаанд цахим системээс авсан нийгмийн даатгалын шимтгэлийн болон татварын өр төлбөргүй тодорхойлолтыг тус тус ирүүлнэ. в) Шүүхийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдэд өр, төлбөргүй талаарх хүчин төгөлдөр лавлагааг цахим системээс авч ирүүлнэ.
ТШЗ 17.3	Техникийн тодорхойлолтод нийцсэнийг нотлоход шаардах баримт бичиг: “Шаардана” 1.Оролцогч, түүний нийлүүлэх бараа нь захиалагчийн шаардсан техникийн тодорхойлолтод нийцэж буйг тендер шалгаруулалтын баримт бичгийн техникийн тодорхойлолтод заасан хүснэгтийн дагуу харьцуулсан хүснэгтийг III бүлэгт заасан техникийн тодорхойлолт гэсэн маягтын дагуу баталгаажуулан ирүүлнэ. 2. Бараа нийлүүлэлтийн хуваарийг III бүлэгт заасан маягтын дагуу баталгаажуулан ирүүлнэ. 3. Барааны үнийн задаргаа, нийлүүлэхээр санал болгох барааны гарал үүслийн мэдээллийг V бүлэгт заасан Маягт 2-ын дагуу баталгаажуулан ирүүлнэ. 4. Баталгаат гэрээний хугацаанд нийлүүлэгчээс шалтгаалах ямар нэг эвдрэл гэмтэл шаардлага хангахгүй бараа материал гарсан тохиолдолд түргэн шуурхай сольж өгөх үүрэгтэй. 5. Нийлүүлсэн автомашины хэвийн ажиллагааг шалгаж техникийн үзлэг, оношилгоонд оруулсны дараа хүлээлгэн өгнө. ✓ Албан ёсны үйлдвэрлэгч компанийн баталгааны хуудас / эсвэл дүйцэхүйц албан бичиг баримт ✓ Мэргэжлийн автомашины үзлэг, оношилгооны үйлчилгээ үзүүлдэг байгууллагын бүх төрлийн эд ангид тус бүрээр үзлэг оношилгоо хийлгэж баталгаажсан дүгнэлтийн хуудасыг бараа нийлүүлэх үед дагалдуулж өгөх. Хэрэв баталгаат хугацаанд ямар нэгэн үйлдвэрийн эвдрэл гэмтэл гарсан тохиолдолд 7 хоногийн дотор эвдрэл, гэмтлийг засварлах шаардлагатай тохиолдолд дахин шинэ машинаар сольж өгөх.
ТШЗ 17.6	Барааны хувьд тасралтгүй, горимын дагуу ажиллуулахад шаардагдах сэлбэг хэрэгсэл, тусгай багаж болон бусад эд зүйлсийн жагсаалт ирүүлэх эсэх, ирүүлэх бол хугацаа: “Тийм” 1.Барааг нийлүүлснээс хойш өгөгдлийн хүснэгтэд заасан хугацааны туршид тасралтгүй, горимын дагуу ашиглахад шаардагдах сэлбэг

хэрэгсэл, тусгай багаж болон бусад зүйлсийн жагсаалтыг тэдгээрийг авах боломжтой хаяг, үнийн мэдээллийн хамт ирүүлнэ.

а.Барааг нийлүүлсний дараах байнгын болон урсгал үйлчилгээний хуваарийг бэлтгэж ирүүлнэ.

б.Тоног төхөөрөмжийн баталгаат хугацаа 36 сараас доошгүй байна.

в.Бараа нийлүүлэх хуваарьт заасан байршилд барааг хүргэж, угсарч суурилуулна.

г.Тоног төхөөрөмжийн ашиглалт, засвар үйлчилгээний сургалтыг холбогдох мэргэжилтнүүдэд зохион байгуулж, шаардлагатай гарын авлагаар хангах үүрэгтэй.

д. Баталгаат хугацааны засвар үйлчилгээг ханган нийлүүлэгч хариуцах үүрэгтэй.

Техникийн тодорхойлолт

“Техникийн тодорхойлолт” хэсэгт “Барааны техникийн тодорхойлолт”-ыг хавсаргана. Тухайлбал, нийлүүлэх бараа нь доор дурдсан техникийн тодорхойлолт, стандартад нийцсэн байна.

Барааны нэр:

№	Захиалагчийн техникийн тодорхойлолт (Тухайн барааны үзүүлэлт тус бүрийг доор жагсааж бичих ба хэрвээ чанарын баталгаат хугацаа шаардах бол бичнэ үү.)	Санал болгож буй техникийн тодорхойлолт (захиалагчийн техникийн тодорхойлолтыг хуулахгүй байхыг анхаарна уу. Зөвхөн санал болгож буй барааны техникийн тодорхойлолтыг бичнэ үү.)	Тайлбар (Санал болгож буй барааны техникийн тодорхойлолтод заасан үзүүлэлтийг нотлох баримт бичиг, мэдээллийг хавсаргана)
1			
2			
3			
...			

Бараа нийлүүлэлтийн хуваарь

[Захиалагч доорх хүснэгтийн 1-6 хүртэлх баганыг, оролцогч 7 дугаар баганыг бөглөнө]

№	Барааны нэр	Тоо хэмжээ	Хэмжих нэгж, тун	Өгөгдлийн хүснэгтэд заасан барааг хүргэх эцсийн цэг	Бараа нийлүүлэх хугацаа	
					Захиалагч бараа хүлээн авах хугацаа (эхлэх болон дуусах хугацаа)	Нийлүүлэгчийн санал болгох хугацаа (Оролцогч энэ баганыг бөглөнө)
1	2	3	4	5	6	7
1	Эмнэлгийн түргэн тусламжийн бүрэн тоноглогдсон автомашин	12	Ширхэг	Нийслэлийн Эрүүл мэндийн газар	Гэрээ байгуулснаас хойш 90 хоногт	[6 дугаар баганад заасан хугацаанд багтаан нийлүүлэхээр санал болгож буй хугацааг бичих]

[Захиалагч байгууллагын нэр]-д

Манай **[оролцогчийн нэр]** нь танай байгууллагаас зарласан **[тендер шалгаруулалтын нэр, дугаар]** тендер шалгаруулалтад **[үнийн хөнгөлөлт тооцоогүй тендерийн үнийг тоогоор болон үсгээр]** төгрөгөөр тендер шалгаруулалтын баримт бичигт заасан хуваарийн дагуу бараа нийлүүлэхээр, доор дурдсан нөхцөлийг баталж энэхүү тендер (цаашид “тендер” гэх)-ийг хүргүүлж байна. Үүнд:

1. Тендер шалгаруулалтын баримт бичиг, түүнд заасан гэрээний нөхцөл (гэрээний ерөнхий нөхцөл, тусгай нөхцөл, гэрээ баталгаажуулах маягт)-тэй танилцаж, бүрэн хүлээн зөвшөөрч тендер шалгаруулалтад оролцсон.
2. Оролцогч, түүний түншлэлийн гишүүн худалдан авах ажиллагаанд оролцохтой холбоотой хуулиар хориглосон нөхцөлд хамаарахгүй бөгөөд үүний дотор дараах нөхцөлийг гэрчилж байна. Үүнд:
 - 2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй;
 - 2.2. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний эцсийн өмчлөгч, хөрөнгө эзэмшигч, хамтрагч, эсхүл эдгээрийг гүйцэтгэж байгаа хувиараа аж ахуй эрхлэгч нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20.2 дахь хэсэгт заасан албан тушаал эрхэлж байсан болон эрхэлж байгаа хүн, эсхүл түүнтэй хамаарал бүхий этгээд биш;
 - 2.3. Захиалагчийн удирдлага, хяналт, захиргаанд ажилладаг албан тушаалтанд ашиг олгодоггүй;
 - 2.4. Оролцогчийг төлөөлж буй этгээд нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 21.1.3 дахь заалтад заасан хязгаарлалтад хамаарахгүй.
3. Тендертэй холбоотой нотлох баримт, мэдээллийг холбогдох этгээдээс гаргуулах эрхийг захиалагчид үүгээр олгож байна.
4. Тендерт үнийн хөнгөлөлт [“санал болгоно” эсхүл “санал болгохгүй” гэж бичих]. [Хэрэв үнийн хөнгөлөлт санал болгох бол түүнийг хэрхэн хэрэглэх нөхцөл, аргачлалыг бичих].
5. Тендер нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасны дагуу тендер нээснээс хойш **[ажлын 30 ба түүнээс дээш өдрийн тоо бичих]** өдрийн хугацаанд хүчинтэй байна.¹
6. Хуулийн 7.1, 22.2, 56.5-д заасныг зөрчсөн болон тендер шалгаруулалтад үнэн зөв, зөрүүгүй орчуулга ирүүлэх үүргээ зөрчсөн тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэх үндэслэл болохыг хүлээн зөвшөөрч байна.
7. Тендерт санал болгосон бараа нь оюуны өмчийн зөрчилгүй, эрхийн болон биет байдлын доголдолгүй болохыг баталж байна.
8. Тендерийг холбогдох журмын дагуу бусад оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч, тендерийг нууцлах аливаа үүргээс захиалагчийг бүрэн чөлөөлж байна.

¹ Хэрэв тендер шалгаруулалт нь урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулагдах бол “5. Тендер нь тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаар хугацаагүй хүчинтэй байна.” гэж сольж бичнэ үү.

[Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд,
эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр,
албан тушаал, гарын үсэг,

***байгууллагын тамга, тэмдэг*]:**

Хаяг:

Маягт 2 Барааны үнийн задаргаа

1	2	3	4	5	6	7	8	9	10	11
№	Барааны нэр	Гарал үүслийн улс	Тоо хэмжээ	Хэмжи х нэгж, тун	Нэгж үнэ	Нэр төрөл бүрийн бүгд үнэ (4х6)	Барааг эцсийн цэгт хүргэхэд шаардагдах дотоодын тээвэрлэлт болон бусад үйлчилгээний үнэ	Бараа нийлүүлэхэд ногдох татвар, хураамж	Нэр төрөл бүрийн нийт үнэ (7+8+9)	Монгол Улсын гарал үүсэлтэй бараа мөн эсэх ²
1										Тийм/Үгүй
2										
...										
	Тендерийн нийт үнэ									

Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд,

эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр,

албан тушаал, гарын үсэг, байгууллагын

тамга, тэмдэг]:

² Монгол Улсын гарал үүсэлтэй бараа мөн эсэх гэдэгт “тийм” гэж бөглөсөн бол түүнийг нотлох баримт бичгийг хавсаргана.